

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 06

Баянхошуу

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орлоготой иргэн


- 1.1.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж "Үйлдвэржилт хөгжлийн корпораци"-аар дамжуулан хүү багатай зээл олгоно.
- 1.1.2 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.
- 1.1.3 Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг сумд хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.6 Иргэдийн туршлага ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно.

1.2 Хуримтлалын нэгдсэн сан ба Орон сууцтай өрх

- 1.2.1 Түрээсийн орон сууц бий болгох, нэмэгдүүлэх.
- 1.2.2 Сумын төвийн дулааны шугамыг өргөтгөж, хувийн орон сууцны тоог нэмэгдүүлэх бодлого барина.


1.3 Эрүүл иргэн

- 1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны "Жишиг загвар төв" байгуулна.
- 1.3.2 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.4 "Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.5 "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, "Эрүүл ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, ур чадварыг тасралтгүй дэмжиж, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулан "Цогц чадамжтай эмч" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.7 Эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг





00000000!



сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн “Эрүүл мэндийн салбарын эелдэг ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.8 Шүдний эмчийн орон тоог нэмэгдүүлж, тоног төхөөрөмжөөр хангана.

1.4 Чанартай боловсрол

1.4.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

1.4.2 Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах дохионы хэлний багш бэлтгэхэд дэмжин ажиллана.

1.4.3 Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.4 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4.5 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.6 Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.

1.4.7 Баянхонгор аймгийн Галуут суманд 240 хүүхдийн сургууль шинээр барина.

1.4.8 Баянхонгор аймгийн Галуут суманд цэцэрлэг шинээр барина.

1.4.9 Сургуулиудын гадна талбайд спорт цогцолбор байгуулна.

1.4.10 Сурагчдын сурлагын амжилт, чанар стандарт хангалтыг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5 Тогтвортой-амар, амгалан гэр бүл

1.5.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5.3 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

1.5.4 Хөдөлмөр эрхлэлт зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.

1.5.5 Гадаадад хөдөлмөр эрхэлж мэргэжил эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэдний орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.5.6 Гэр бүл дэх эцэг эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулна.

1.5.7 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.


1.6 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

1.6.1 Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшлийг сайжруулах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.6.2 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.6.3 Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.

1.6.4 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж хяналтыг сайжруулна

000000002

6417
ЮА006



1.7 Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.7.1 Залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сайжруулах "Залуу-манлайлал" төсөл хэрэгжүүлж ажиллана.
- 1.7.2 "Залуус бидний төлөө- бид залуусын төлөө" төсөл хэрэгжүүлж, залуусын оролцоотой төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.7.3 Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.8 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих

- 1.8.1 "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.8.2 Хөдөө орон нутаг сумдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, тэгш хамран сургах, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг дэмжин ажиллана.

1.9 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

- 1.9.1 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төв, байгуулна.
- 1.9.2 Ахмадын зөвлөх үйлчилгээг салбар бүрд хэрэгжүүлнэ.
- 1.9.3 Тухайн баг сумын харьяат ахмад настнуудад чиглэсэн олон талт үйлчилгээг зохион байгуулна.

1.10 Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.10.1 Соёлын салбарын хүний нөөцийг чадваржуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.10.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.10.3 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, сумд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.
- 1.10.4 Орон нутагт ажилладаг магадлан итгэмжлэгдсэн спортын клубийг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.10.5 Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлэх журам боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.10.6 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.
- 1.10.7 Монголын үндэсний баяр наадам, үндэсний спортын язгуур шинжийг хадгалан уламжлуулах сурталчлан таниулах, үндэсний спортын наадмыг зохион байгуулна.
- 1.10.8 Галуут суманд Спортын цогцолбор байгуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулж санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор "Тунгалаг санхүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Арьс шир боловсруулах цехийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 2.3 Галуут, суманд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.4 Сарлагийн хөөврөөр хийсэн бүтээгдэхүүн болон хонины ноосоор хийсэн дулаалгын материалыг зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 2.5 Сумын төвийн иргэдийн усан хангамжийг сайжруулах нэмэгдүүлэх хатуулаг багатай ундны ус зөөвөрлөх усны зөөврийн авто машинтай болох

000000003

14354
7900



- 2.6 Сумын хэмжээний усан хангамжийн их үүсвэрүүдэд түшиглэсэн газар тариаланг бий болгох, сумын хүнс ногооны нөөцийг дотооддоо бэлтгэх, хадгалах зорь барих

2.1 Төрөлжсөн аялал жуулчлал

- 2.1.1 Төвлөрсөн замын дагуу болон аялал жуулчлалын маршрутаар үйлчилгээний дэд бүтцийг бий болгож, ажил үйлчилгээ эрхлэх газрыг орон нутгийнханд олгох замаар иргэд аж ахуйн нэгжийн бизнес, ажил эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.2 Амралт сувилал, аялал жуулчлал, үйлчилгээний газарт стандартын шаардлага хангасан ус хангамж, ариун цэврийн байгууламжийг үе шаттай байгуулна.
- 2.1.3 Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг эрэмбэлж үйл ажиллагааг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах мөн нөөц газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.1.4 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуй нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.
- 2.1.5 Галуут сумын Өхэг, Өргөөт, зэрэг масс жуулчид ирдэг газруудын менежментийг сайжруулж дэд бүтцийг хөгжүүлнэ.

2.2 ДЭД БҮТЭЦ

- 2.2.1 “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж хорооллыг зам гэрэлтүүлэгтэй болгоно.
- 2.2.2 Сумын гэр хорооллын айл, өрхүүдийн дунд бохирын нэгдсэн шугам татах, био жорлон нэвтрүүлэх замаар хөрсний бохирдлыг багасгана.
- 2.2.3 “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.4 Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө.
- 2.2.5 Сумын төвд цэцэрлэгт хүрээлэн тоглоомын талбай байгуулах.
- 2.2.6 Сумын төвд аянга цахилгаан зайлуулагч хийх.

2.3 Авто зам

- 2.3.1 Сумын төвд 2 км хатуу хучилттай авто зам тавина.
- 2.3.2 Зарим багуудын нутаг дэвсгэрт иргэд зорчих хүндрэлтэй зам давааг засаж янзлах, сайжруулах

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Төрийн байгууллага бүрт төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”ийг батлуулан хэрэгжүүлж, “Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.
- 3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.
- 3.3 Нийгмийн хариуцлагаа ухамсарласан, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана

[Handwritten signatures]

000000004


742



- 3.4 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.
- 3.5 Мэдээлэл технологийн шинэчлэлийг төрийн үйл ажиллагаанд тасралтгүй нэвтрүүлж, иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.6 Хариуцлагатай төрийн албан хаагч, хариуцлагатай засаглал хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 3.7 3, 5, 6 дугаар багийн багийн төвүүдийг шинээр барих, засварлах, өргөтгөх асуудлыг шийдвэрлэж засаг захиргааны анхан шатны нэгжид төрийн үйлчилгээг төвлөрүүлэх арга хэмжээг авна.
- 3.8 Шаардлагатай төрийн байгууллагуудад авто машины парк шинэчлэлт хийнэ.
- 3.9 Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ажиллаж амьдрах боломжийг сайжруулах.
- 3.10 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах нөхцөлийг сайжруулах
- 3.11 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.12 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлж зохих нөөцийг бүрдүүлнэ.
- 3.13 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд зориулалттай эрсдэлийн сан байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах.
- 4.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгож, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлээр хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 4.3 Бэлчээрийг нөхөн сэргээх "Малчдын дундын сан" байгуулна.
- 4.4 Түүх, соёлын дурсгалт газар, ус, ой, эко систем, ховор амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэд, бүлэг нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 4.5 Гол, горхи, булаг, шандны эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад гүнээс чийг татаж амьдрах чадвартай мод тарьж ногоон хэрэм бий болгоно.
- 4.6 Ашиглагдаагүй байгаа бэлчээр нутагт худаг гаргах, булаг шанд, цас борооны ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах хэлбэрээр усны нэмэлт эх үүсвэрийг бий болгож, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг усжуулсан, ойжуулалт хийсэн малчдын бүлэг, хоршоо, байгаль хамгаалах



 000000005



- нөхөрлөлүүдийн санал санаачилгыг дэмжиж, санхүүгийн дэмжлэг олгох, урамшуулах механизмыг бий болгоно.
- 4.7 Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэд техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, Орон нутагт татвараа төлдөг, байгалийн нөөц ашигласан төлбөрөө хугацаандаа төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 4.8 Бичил уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, эрх зүйн орчинг боловсронгуй, бичил уурхайчдад ээлтэй бодлого боловсруулж бичил уурхайчдаа дэмжинэ.
- 4.9 Сумын Хогийн цэгийг стандартад нийцсэн Ландфилийн аргаар дарж булшлах цэгцлэх ажлыг хийнэ.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.
- 5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 5.3 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлж өргөжүүлнэ.
- 5.4 Иргэдээ орон нутагт үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах "Органик хүнс" төсөл хэрэгжүүлж, өрхийн тариалалтыг дэмжиж дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангана.
- 5.5 Нутгийн шилмэл омог, үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.
- 5.6 Малын халдварт өвчин тархах, давтамжийн судалгааг үндэслэн мал эмнэлгийн цогц арга хэмжээг эрчимжүүлж, эрүүл бүс нутаг гэсэн статусаа баталгаажуулна.
- 5.7 Сумын хэмжээнд атаршсан талбайд үр тариа жимс жимсгэнэ, малын тэжээл, бут сөөг тариална.
- 5.8 Талын толгойн услалтын системийн ашиглалтыг сайжруулж, төмс хүнсний ногоо, тэжээлийн болон эмийн ашигт ургамал тариалах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.9 Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй байгуулах санал, санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.10 Мах, сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлана.

---oOo---

[Handwritten signatures]

0000000000